

ЗАСГИЙН ГАЗАР

ОХУ-ТАЙ ТӨМӨР ЗАМААР АЧАА ДАМЖУУЛАН
ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭГ ЭНЭ САРЫН 23-НД
ҮЗЭГЛЭХ НЬ

V нүүрт



**МОНГОЛ АРДЫН НАМ
ХАНДИВЫН ДАНСАА НЭЭЛЭЭ**

Иргэн та хандив оргоходоо
Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйд заасны дагуу:
50.1.1 Иргэн турван сая тогтол хүргэлтийн дугаар/
50.1.2 Хуулийн этгээд арван сая тогтол хүргэлтийн дугаар/

Сонгуулийн тухай хуулийн 40.3-д:
..“Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийн нээлгээн, сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулна” гэсэн, заалтын удзслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дансыг нээсэн тул намын гишүүд, дэмжинчид, дэмжигч байгууллага, иргэд та бүхийн хандив оргохийн хүснэгтэй.

**“ХААН БАНК”
5115028001 тоот данс**

Дугаарын **60** мөр

Хувьцааныхаа
мөнгийг салхинд
хийсгэвчихэв дээ

Э.ТУУЛ

Тэртээ 1990 онд авв, ээж минь боломжийн ажилтай, бид ч цалин монго гайгүй авдаг дажгүй амьдралтай хүмүүсийн тоонд ордог байлаа шүү дээ. Гэтэл гэнэт л нээг оглоө ажилдаа очижад ажлыг нь төрийн мэдээлэс гаргаж, хувь хүнд очсон байв. Тухайн үед хувьцаа, цэнхэр ягаан тасалбар, хувьцаа эзэмшигчдийн талаар ямар ч ойлголтгүй байсны улмаас ногдол ашиг энэ тэр гэж нэхэлгүй, тэр читт нь орхисон түүхтэй. Харин 2011 онд Монгол Улсын иргэн бүрт “Эрднэс Тавантолгой” ХК-ийн 1072 хувьцааг огснон. Энэхүү хувьцаа онгөрсөн таван жилийн хугацаанд амьгүй байсаны эцэст сая нэг амь орлоо.

Төгсгөл нь II нүүрт



Гэрэл зурагийн Г.АРГУУЖИН

Туул голын тухай хууль санаачлах УЛС ТӨРИЙН ХҮЧИН ХЭРЭГТЭЙ БАЙНА

Н.ПУНЦАГБОЛД

ҮИХ-ын ээлжит сонгууль болоход хэдхэн хоног үлдээд байна. Улс төрийн нам, эвслүүд уламжлал ёсоор оөрсдийн мөрийн хотолбөрийг боловсруулж, өмнөх шиггээ

ард олон биднийгээ сайхан амьдралуна гэж амалсан. Их ч олон ажил хийхээр мөрийн хотолбортой тусгаж. Гэхдээ энэ дунд нэг зүйлийг бас сануулах хэрэгтэй байна. Тэр энэ нам, эвслэл нь хамаагүй. Төрийн түшээ болж сонгогдсон, одоо сонгогдох бүх хүнд хамаатай

нэг зүйл бол Туул голын тухай хууль юм. “Монголын мэдээ” сонин 2012 оноос өмнө энэ санаачилгээ гаргаж, олон гишүүнтэй ярилцаж, санаа бодлыг нь сонч байлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Төгсгөл нь V нүүрт

“ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨВ”-Д ХАМТРАН АЖИЛЛАХ САНАЛАА ИРҮҮЛНЭ ҮҮ

Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга эзмжээний тухай” 2013 оны 152 дугаар тогтооны хүрээнд БНХАУ-ын Тянъянин боомтын Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтад хамтарсан компани байгуулж “Тээвэр ложистикийн төв” төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий хувийн хөвшлийн аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж зохион байгуулахыг “Монголын төмөр зам” ТӨХК-д даалгасан юм.

Иймд дээрх төслийн хүрээнд Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсийн татварын хөнгөлөлттэй эко орчиндаа үйлдвэрлэл эрхлэх, дахин боловсруулалт хийх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлох болон БНХАУ-ын зах зээлд нийдүүлэх дотоодын аж ахуйн нэгжүүд төслийн саналаа ирүүлнэ үү.

Дунзян чөлөөт худалдааны боомт бүсэд үйлдвэрлэл явуулахад дараах хөнгөлөлтийг эдлэнэ. Үүнээс:

1. Чөлөөт бүсэд бүртгэлтэй аж ахуйн нэгж эхний хоёр жилд үйл ажиллагааны татвараас 100%, дараагийн 3 жилд үйл ажиллагааны татвараас 50% чөлөөлнө; Харин ашиг олсон жилээс эхлэн эхний хоёр жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 100%, гурав дахь жилийн төслийн 50%-ийн хөнгөлөлтийг үзүүлнэ;

2. Гадаадын ачаа барааг чөлөөт бүсэд оруулахад импортын гаалийн татвар болон НӨАТ-аас чөлөөлнө.

3. БНХАУ-ын дотоодын аж ахуйн нэгжүүд ачаа барааг чөлөөт бүсэд оруулахад экспортын татварыг буцаан олгоно.

4. Чөлөөт бүс дотор аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл эрхлэх, дахин боловсруулалт хийхдэд НӨАТ-аас чөлөөлөгднө.

5. Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг чөлөөт бүсэд худалдаалахад НӨАТ болон хөрэглээний татвараас чөлөөлнө.

6. Чөлөөт бүсийн аж ахуйн нэгж үйлдвэрлэл эрхлэхдээ зориулсан хөрэглээний ус, цахилгаан, газ, дулааны төлбөрийн татварыг буцаан олгоно.

Санал авах хугацаа

2016 оны 8-р сарын 1-ний өдрийг хүртэл “Монголын төмөр зам” ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn шахим хаягаар “Үйлдвэрийн төслийн санал” гэсэн гарчигтай ирүүлнэ үү.

ХАЯГ:

“Монголын төмөр зам” Төрийн Өмчтэй Хувьцаат Компани Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-23, UBH центр, 8-р давхар Улаанбаатар 14230

Утас: (976) 99140072, 91999333

Факс: (976) 70106644

Вебсайт: www.mtz.mn

ДОТОР НҮҮРТ



ИХ
БРИТАНИ
ЕХ-НД
ҮЛДЭХ ҮҮ,
ЭС ҮЛДЭХ
ҮҮ

6

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

Б.ЧУЛУУДАЙН ТАЛААРХ ГҮТГЭЛГИЙГ БАРИМТТАЙГААР НЯЦААВ

Б.ДАВАА

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлэзүйн консервиумаас зөвлөгөө авч, оффшор бүсэд компани байгуулж байсан эрхмүүдийн нэсрэгийг зарлаж, томоохон дуулианыг тарьсан билээ. “Панамын баримт бичиг” изргэй тус мэдээлэлд давхардсан тоогоор Монголын 49 эрхэм нэр холбогдсоны нэг нь Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүлийн хүү Б.Чулуудай байсан юм. Тус мэдээлэл нийтэд ил болсон даруйд Б.Чулуудай “Би оффшор бүсэд компани байгуулсан нь үнэ. Гэхдээ уг компаниа нээгээд л орхисон. Ямар нэгэн гүйлгээ хийгээгүй. Тус компани нь үйл ажиллагаа явуулагчай байж тайлан буутгасан” гэсэн тайлбарыг хийж байсан билээ. Харин Нийслэлийн засаг дарга Э.Бат-Үүл “Миний хүү оффшор дахь компаниараа дамжуулан ганц л удаа гүйлгээ хийсэн байвал би албан тушаалаасаа татгалзана.

Төгсгөл нь II нүүрт



ХИНДИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛ

Улаанбаатар дахь Энэтхэгийн Элчин Сайдын Яам Зүүн Хүрээ Дашчойлийн Хийд дээр Хиндий хэлний хичээлийг үнэ төлбөргүй явуулж байна. Хичээл Даваа, Лхагва, Пүрэв гарагт 1430-1630 цагийн хоорона явагдана. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Хиндий хэлний багш Хатагтай Сийлэгмаа (утас 99125258)-тай холбогдох юмуу cons.ulaan@mea.gov.in буюу hoc.ulaan@mea.gov.in хаягаар бичнэ үү.

Өчигдрийн 19.00 цагийн байдаа

ХААН банк



	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1945.00	1960.00	ФУНТ	2739.00	2822.00	АМ.ДОЛЛАР	1948.00	1962.00
ЕВРО	2170.00	2222.00	РУБЛЬ	28.00	31.80	ЕВРО	2178.00	2225.00
ИЕН	18.48	18.95	ЮАНЬ	294.30	297.80	ИЕН	18.53	18.98

ҮЗЭЛ БОДОЛ

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

“Ганц голд зориулсан хууль гэж юу байдаг юм” хэмэн яргалх цөөн хэдэн хүнийг эс тооцвол Улаанбаатар хотынхны ундны усны ганц эх үүсвэр болж байгаа Туулаа хуулиар хамгаалах нь зөв гэдэг дээр санал нийлж талаар хэрэгжүүлж байна. Бугат хотынхон гэхэд агаар, голын сав газрын бохирдлыг арилгах, ундны усны эх үүсвэрийг хамгаалах ажлыг цогцоор нь зохион байгуулж. Тодруулбал, 12 дугаар таван жилийн хүрээнд бохир ус

...Улаанхад,
Ордос, Бугат
хотууд шинэ
хуулийн дагуу 64,
56, 55 хэргийг
шийдвэрлэсэн
байна. Наад
захын жишээ
дурьдахад,
Өвөр Монголын
засаг захиргаа
хуулиа ингэж
сурталчилж,
биелэлтэд нь
анхаарч байна.
Гэтэл манай тийм
юм алга. Нэг л
сайхан багц хууль
гаргасан, хаана
ч байгаа юм бүү

цэвэршүүлэх станц 11-ийг байгуулжээ. Ингэснээр өдөрт 501.5 мянган тонн ус цэвэршүүлэх хүчин чадалтай болж. Зөвхөн нүүрсний болоод хөрсний бохирдолтой тэмцээд зогсохгүй усаа хамгаалах, цэвэршүүлэх тал дээр цогц ажил хийж байна. Энэ нь ногоон ирээдүйг цогцлоохын хажуугаар

агаарын бохирдолтой тэмцэх нэг хэлбэр болж байгаа аж. Хятадын Тяньжин хотын Хайхэ гол гэж байна. Тяньжин хотын төвөөр урсдаг юм билээ. Манай Сэлбэ голыг бодвол том, 1090 км урсдаг гол юм билээ. Гэхдээ Тяньжин хотын төвдөө тус гол руу чиглэсэн мега төслийг хэрэгжүүлснээр нутгийнхан төдийгүй гадаадын жуулчдын очих дуртай газрын нэг болж. Нөгөө талаар хотын төвдөө том голтой байснаар агаарын бохирдлыг багасгах нэг том хүчин зүйл болдог аж. Тэгээд манай улс Сэлбэ гол дээр хэрэгжүүлж байсан төслюю үр дунг узэх хэрэгтэй байгаа юм. Хайхэ гол том учраас үерлэж, эрэг орчмын айлууд усандаа автдаг байсныг далангаар хашсан юм билээ л дээ. Сэлбээ дээр бол бид урсацийг нь нэмэгдүүлэх, цаашлаадорчныг нь сайджуулж, Улаанбаатар хотынхны амар, зугаалах салхилах газрыг нэгээр нэммээр байна. Цаашлаад агаарын бохидолтой тэмцэхэд ч хэрэгтэй.

Хятадууд байгалах хамгаалах хуулийнгэж хэрэгжүүлж байна, харин Монголд.

Дугаарын 60 мөр

Хувьцааныхаа мөнгийг салхинд хийсгэчихэв дээ

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Засгийн газар ээлж

бус хуралдаанаар “Эрдэ

Тавантолгой"-н 323 ши

хувьцааг нэрлэсэн үнээр
нь иргэдээс худалдаж
авах асуудлыг хэлэлцэн
шийдвэрлэсэн. Тодруулбал,
Монгол Улсын иргэдэд
эзэмшүүлсэн “Эрдэнэс
Тавантолгой” ХК дахь
өөрийн эзэмшлийн
хувьцаагаа худалдах хүсэлт
гаргасан иргэний эзэмшиж
байгаа 1072 хувьцааны 30
хувьтай тэнцэх буюу 323
ширхэг хувьцааг нэрлэсэн
үнээр нь иргэдээс худалдаж
авах шийдвэрийг Засгийн
газрын хуралдаанаас
гаргасан юм.

Сайн хувьцаа
хэмээх энэ арга хэмжээг
хэрэгжүүлэх хүрээнд
цаашид иргэдийн гарг үлдэх
буоу 70 хувьтай тэнцэх
хувьцааг нь Монголын
хөрөнгийн биржээр
дамжуулан худалдан
авахаар төлөвлөж байна.
Иргэдийн 1072 хувьцааг
худалдан авах эрх зөвхөн
Засгийн газарт нээлттэй.
Өнгөрсөн хугацаанд
Засгийн газар иргэдийн
тодорхой хэсгээс “Эрдэнэс
Тавантолгой” ХК-ийн
хувьцааг нь нэрлэсэн
үнээр худалдан авсан.
Нийт хоёр сая 858 мянган
иргэн хувьцаа эзэмшигэнээс
давхардсан тоогоор 278
мянган оюутанд нийт 138
тэрбум төгрөг, 2011 онд
эрүүл мэндийн даатгалын
шимиgtэл хэлбэрээр 615
мянган иргэнд нийт
4.8 тэрбум төгрөгөөр,
ахмад болон хөгжлийн
бэрхшээлтэй 322 мянган
иргэнд 322 тэрбум
төгрөгөөр давхардсан
тоогоор нэг сая 216 мяняга
734 иргэнд 464.8 тэрбум
төгрөгөөр хувьцааг нь
мөнгөжүүлсэн байна.

Эдгээрээс бусад саяа бүү
мянган иргэний хувьцаа
мөнгөжөөгүй байгаа юм.
Эдгээр иргэд өөрийн
эзэмшилийн хувьцаагаа
худалдах хүсэлт гаргавал
эхний ээлжинд 323 хувьцааг
нь нэрлэсэн үнээр нь
худалдаж авахаар болсон.
“Эрдэнэс Таван толгой” ХК-
ийн 1072 ширхэг хувьцааны
30 хувийг Засгийн
газарт худалдах иргэд
өнгөрөгч даваа гарагаас
арилжааны банкуудад
хүсэлтээ гаргаж эхэлсэн
бөгөөд баасан гарагийн
мэдээллээр 650 мянган
иргэн хувьцаагаа худалдах
хүсэлтээ банкинд гаргасан
байна билээ. Албаныхны
мэдээлж буйгаар хүсэлт
гаргаснаас долоо хоногийн
дараа эхний 100 мянган
төгрөг дансанд нь орох
учиртай. Тэгвэл Засгийн
газрын шийдвэрийн үр дүн
өчигдрөөс гарч, иргэдийн
дансанд хувьцааны эхний
ээлжийн 100 мянган төгрөг
орлоо. Гэтэл нөгөөтгэйгүүр
хувьцаагаа зарах нь ямар ч
ашигтгүй, хадгалж байсан
нь дээр, илүү их үнэд хүрээ
гэсэн хүмүүс бий. Яах вэ хүн
хүний л дур. Үндсэндээ одоо
Засгийн газрын худалдаж
авч буй хувьцааг эргүүлээд
иргэд худалдаж авах эрх нь
нээлттэй болохоор үүнд нэг
их санаа зовох шаардлага
үгүй байх.

Харин хувьцаагаа зарсан иргэд минь Баабар гуайн хэлснээр “Олсон мөнгөө бүгдээрээ хувааж аваад жорлон руу асган нийтээр архидан согтуураад өнгөрөх вий” гэдэг шиг юм болов. Хүн бүхэн орж ирсэн мөнгөө дураараа зарах эрхтэй ч, хувьцааныхаа монгийг л салхинд хийсгэлгүй, юм болгочихвол хэрэгтэй байх даа.

ШУУРХАЙ МЭДЭЭ

НЭГДСЭН ТӨВҮҮД ГАДААД ПАСПОРТ СУНГАХГҮЙ

Н.БАТЗАЯА

Энэ сарын 17-нд улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас иргээдээд үзүүлэх үйлчилгээнд өөрчлөлт оруулж, гадаад паспортыг төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээс захиалах боломжтой болсон. Энэ талаар Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын хэвлэл мэдээллийн ажилтан Ч.Нямцээгээс зорим зүйлийг тодрууллаа.

-Иргэд гадаад паспорт захиалахын тuld заавал 100 айлын иргэний бүртгэл мэдээллийн төв орох шаардлагатай болсон. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Иргэдийн хувьд гадаад паспорт захиалах гэдэг маш төвтэй асуудал байдал. Паспортаа захиалахын тuld дугаарлаж зогсоно. Авахын тuld ч гэсэн дугаарлаж зогч байж авдаг. Тиймээс манай улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас бүртгэлийн үйлчилгээний шат дамжулагыг бууруулж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилтын хүрээнд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд гадаад паспортын үйлчилгээг нэвтрүүлсэн.

-Энэхүү үйлчилгээг төрийн нэгдсэн төвийн үйлчилгээнд нэвтрүүлснээр иргэний бүртгэл, мэдээллийн газрын ачаалал бууруч байгаа байх?

-Тийм. Гадаад паспорт захиалах үйлчилгээг төрийн нэгдсэн төвд шилжүүлснээр нэгдүгээрт

хүлээлт, чирэгдэл арилах юм. Хоёрдугаарт, 100 айлд байрлах иргэний бүртгэл, мэдээллийн төвийн ачаалал баагасах давуу талтай.

-Бүх нэгдсэн төвүүдэд гадаад паспорт захиалах боломжтой юу?

-Тийм. Дунжингиарав, Драгон, Мишээл төвүүдээс гадаад паспортаа захиалах боломжтой. Иргэд ойт байрлах төрийн үйлчилгээний нэгдсэн төвд шилжсэнээр олон давуу талууд бий болсон. Тухайлбал, гадаад паспорт шинээр захиалах иргэдээс цээж зураг зайлшигүй шаардлагад байсан бол Дунжингиарав, Драгон, Мишээл төвөөр үйлчилүүлэх иргэдээс гадаад паспортын зураг шаардахгүй. Бүртгэлийн ажилтан тухайн иргэний зургийг бүртгэл хийх уедээ авах юм. Энэ мэтийн давуу талууд байгаа.

-Нэгдсэн төвүүдэд гадаад паспорт захиалахын тuld ямар материал бүрдүүлэх шаардлагатай вэ?

-Тухайн иргэн гадаад

паспорт анх удаа авч байгаа бол иргэний үнэмлэх, төлбор толсон баримтаа авч ирэх хэрэгтэй. Харин хүчинтэй байдал нь алдагдсан болон хугацаа нь дусуч дахин авах бол хучин гадаад паспорт, иргэний үнэмлэх, төлбор толсон баримт шаардлагатай.

-**Захиалсан паспортаа хаанаас авах вэ?**

-Захиалсан гадаад паспортын буцаан олголтыг иргэн өөрийн хүснэгтээр "Монгол шуудан" компаниар дамжуулан гэрийн болон ажлын хаягаараа авах боломжтой. Мөн захиалсан газраасаа заасан хугацаанд авч болно.

-**Гадаад паспортын сунгальт хийх ўу?**

-Үгүй. Зөвхөн гадаад паспорт шинээр захиалах бол төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэдхандаж болно. Хэрвээ гадаад паспортаа сунгуулах бол 100 айлд байрлах Гадаад паспортын хэлтэст хандаж сунгуулна.

-**Өмнө нь 100 айлын иргэний бүртгэл мэдээллийн хэлтэст гадаад паспорт захиалсан байсан хүмүүс хаанаас паспортаа авах вэ?**

-Өмнө нь гадаад паспортаа 100 айл дахь иргэний бүртгэл мэдээллийн хэлтэст захиалсан байсан хүмүүс тэндээсээ очиж авна. Нэгдсэн төвүүдэдшиинээр захиалж байгаа хүмүүс очих юм. Зөвхөн гадаад паспорт захиалах үйлчилгээ нь л нэгдсэн төвүүдэд шилжсэн гэсэн уг. Харин сунгуулах үйлчилгээ нь 100 айлын

иргэний бүртгэл, мэдээллийн хэлтэстэй хэвэрээ байгаа.

-**Гадаад паспорт шинээр авах, сунгуулахад ямар үнэтэй байдаг юм бэ?**

-Гадаад паспортыг нэг болон таван жилийн хугацаатайгаар шинээр авч болно. Жилээсээ хамаарчүнээль өөр. Тухайлбал, нэг жилээр гадаад паспорт авах бол 22500 төгрөгийн үнэтэй. Таван жилээр авах бол 32500 төгрөгийн үнэтэй байдаг. Хэрвээ гадаад паспортаа яаралтай ажлын гурав хоногт гаргахаар бол нэг жил, таван жил ялгаагүй 10 мянган төгрөг нэмэгддэг юм.

-**Сунгуулахад ямар үнэтэй вэ?**

-Гадаад паспортыг 1-5 жилийн хугацаатайгаар сунгуулах боломжтой. Нэг жилээр 4500, хоёр жилээр 6500, гурван жилээр сунгуулах бол 8500 төгрөгийн үнэтэй. Харин дөрөн жилээр 10500, таван жилээр сунгуулбал 12500 төгрөг төлөх ёстой. Гадаад паспортаа хаяж үрэгдүүлж, гэмтээсэн тохиолдолд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Эзэмших, ашиглах хугацаа дууссан, паспортаад улсын хил нэвтрэх тухай тэмдэглэл хийх тогтуулдаг. Энэхүү тогтуулийг паспорт авах унийн дун дээр нэмж тооцож, авдаг.

-**Ямар тохиолдолд гадаад паспортыг хүчинтүй болгодог вэ?**

-Гадаад паспорт хүчинтүй болгох хэд хэдэн тохиолдол бий. Тухайлбал, эзэмших, ашиглах хугацаа дууссан,

паспортаад улсын хил нэвтрэх тухай тэмдэглэл хийх зайгүй болж хуудас дууссан байвал хүчингүй болдог. Мөн паспорт эзэмшигчийн зураг танигдахааргүй өөрчлөгдхөх, гоо сайхны мэс ажилбар хийгээсэн бол хүчингүй болгон. Түүнчлэн эрх бүхий байгууллагын шийдвэрээр овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар өөрчилсон, гадаад паспорт болон түүнтэй адилтгах баримт бичгийг бусад шилжүүлж хуурамчаар ашигласан бол тухайн иргэний паспортыг хүчингүй болдог юм. Тухайн иргэн өөрийн болгоомжгүйгээс болж гадаад паспортаа гэмтээсэн, хаясан, үрэгдүүлсэн, эсвэл паспортаад бичсэн уг, үсэг, бичлэг, зурагт хууль бусаар засвар хийсэн байвал мөн хүчингүй болгодог.

-**Хүчингүй болгоход төлбөр хураамж төлдөг ўу?**

-Гурван тохиолдоос бусад үед "Захиргааны хариуцлагын тухай хууль"-ийн 27.1 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Эзэмших, ашиглах хугацаа дууссан, паспортаад улсын хил нэвтрэх тухай тэмдэглэл хийх тогтуулдаг. Энэхүү тогтуулийг паспорт авах унийн дун дээр нэмж тооцож, авдаг.

Улаанбаатар-Бусан чиглэлд тогтмол нислэг үйлдээнэ

Х.НАРАНЦАРАЛ

Солонгосын агаарын тээврийн "Эйр Бусан" компани Улаанбаатараас БНСУ-ын Бусан хот руу тогтмол нислэг хийхээр болжээ.

Үйнэйхэн холбогдуулан тус компаний Монгол дахь суурин төлөөлгөч Ким Жан Ху, салбарын менежер Д.Баярсайхан нар очигдогор "Монгол ньюс" мэдээллийн төвд хэвлэлийн хурал хийлээ. Тодруулбал "Эйр Бусан" компани нь 2007 онд байгуулагдсан. Нийт 250 нисгэгч, 400 онгоцын үйлчилгэч, 350 ерөнхий ажилтантай үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд УБ-Бусан чиглэлийн анхны нислэгээ энэ сарын 24-ны 13 цаг 40 минутанд хийх юм байна. Анхны нислэгийн тийз авсан эхийн 100 зорчигчдод онцгой хямдлаар бэлэг барина. Мөн Бусан хотод байрлах Дэдүн эмнэлгээс эрүүл мэндийн нэгдсэн шинжилгээг 20 хувийн хөнгөлттэй өгөх эрхийг олгох аж. Дашпрамд дурьдаад долоо хоногийн мягмар, баасан гарагуудад Airbus A320 онгоц нислэг үйлдэх ба нэг талын тийзний үнэ 183,000 воны үнэтэй юм байна.

Авто замын ослын улмаас дөрвөн хүн амиа алжээ

Улаанбаатар хотын замын цагдаагийн газрын ЖШУХ дээр онгорсон амралтын өдрүүдэд нийт 529 дуудлага бүртгэгджээ. Үүнээс 367 нь зам тээврийн осолтой холбоотой дуудлага байгаа аж. Мөн гэмтэй хэргийн шинжтэй 25 гомдол бүртгэгдэж, нэг хүний амь нас хохирчээ. Тодруулбал, БЭД-ийн нутагт Эхтэйланын оркон чөлөө, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн урд замд H.Sonata маркийн авто машины жолооч А нь явган зорчигч 26 настай эрэгтэй Б-т мөргөж амь наасыг нь хохирсоос байна. Мөн БГД-ийн нутагт Дунд нолын гудамж, Нарны хорооллын 1-р байрны хойд замд T.Prius маркийн авто машины жолооч С нь унадаг дугуйн унаж явсан долоон настай эрэгтэй Т-т мөргөж гэмтээсэн

хэрэг гарчээ. Түүнчлэн ходоо орон нутгийн замд осол гарах нь ихэссэн талаар Улаанбаатар хотын замын цагдаагийн газраас мэдээлэлээ. Тухайлбал, Төв аймгийн Сэргээн сум Улаанбаатар хотоос 132-133 дахь км-т асфальтан замд T.Ipsum маркийн гурван зорчигчтой авто машин онхолдажээ. Ослын улмаас жолооч 57 настай эрэгтэй 3, зорчигч 18 настай эмэгтэй Б нарын амь нас хохирч, нэг хүн гэмтсэн байна. Мөн Ховд аймгийн Үенч сумын Жаргалант багас баруун тийш Күв гэх широон замд Б жолоочтой улсын дугааргүй мотоцикл онхолдаж жолооч 38 настай эрэгтэй Б нас барсан хэрэг гарсан аж. Тиймээс замын цагдаагийн газраас хөдөө орон нутгийн замд хурд хэтрүүлэхгүй байхыг анхаарууллаа.

Элсэлтийн шалгалт будлиантай болсон гэв

Х.НАРАНЦАРАЛ

Энэ жил Монгол Улсын хэмжээнд 37200 сургач элсэлтийн ерөнхий шалгалт огч дууссан. Жил бүр элсэлтийн шалгальтын дараа шалгальтын хариу болон сургуулийн хуваарын зарагдсан гэх мэт асуудлууд үүсдэг. Энэ жил 3 ялгаагүй шалгальтын материалын 200-500 мянгаар зарагдсан гэх мэдээлэл тарсан. Тэгвэл энэ тухай сургуулийн холбооны тэрүүн О.Сэлэнгэ, "Зуун билин" сургуулийн математикийн багийн X.Сайханбileл, сургчид болон эцэг, эхийн төлөөллийд очигдог "Монгол ньюс" мэдээллийн төвд мэдэгдэл хийлээ. Хурлын үеэд X.Сайханбileл "Бид таамаг төдий зүйл биш, баримт дээр тулгуурлан энэхүү хурлыг зарлаж байна" хэмээлээ.

Математикийн шалгальтыг авсан одор сургчдын дунд шалгальтын хариулагыг 500 мянгаар худалдаж авсан гэх мэдээлэл гарсан. Удалгүй миний таньдаг багийн "Миний давтлага огдог байсан сургач надуу хэдэн бодлого явуулаад, "Багши аа, үүнийн бодод огтооч" гэж гүйснэ дагуу би бодож огсон. Гэтэл тэр бодлогууд элсэлтийн шалгальтын D,C вариант байсан" гэх мэдээллийг надад огсон. Энэгээ, эхчүүд, хүүхдүүдээс ч ийм гомдлууд ирж эхэлсэн. Мөн шалгальтын зарагдсан гэх хариулт миний бодсонтой яг таарч байгаа учраас бид шалгальтын материалын задарсан гэж үзж энэ асуудлыг шалгаж огноо ўу хэмээн БҮГ-д мэдэгдэл хүргүүлж байна" хэмээлээ.



СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Хачигт халдвараас сэрэмжүүлж байна

Манай улсад 43 зүйлийн хачигт байдаг бөгөөд бие гүйцэн хачигийн идэвхтэй ўе нь хавар, зуны улирал байдаг ажээ. Хачгууд нь овчин үүсгэгч нян, вирус, эгэл биетэн зэргийг биедээ агуулж, мал амьтны пусыг сорж хүн, амьтанд дамжуулдаг байна. Манай улсад хачигт энцефалит вирус, боррели, рикетсээр халдварлагдсан торлийн овчилж зонхилюн тохиолдож, хүндэрээ үүсгэдэг. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн зуны амралт эхэлж аялал зугаалга, зуслан болон хөдөөд орон нутагт зорчих хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулж хачигт халдвараас өөрийгөө болон гэр бүлээ хамгаалахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газраас анхаарууллаа.

"Playtime-2016" наадам үзэх хүмүүст үнэ төлбөргүй автобусаар үйлчилнэ

"Найрсаг Улаанбаатар" хотөлбөрийн хурээнд "PLAYTIME-2016" олон улсын амьд хөгжмийн наадмыг гурав дахь жилдээ

СУРТАЛЧИЛГАА**ЗӨВХӨН 6-Р САРД**

**КОМПЬЮТЕР ХУДАЛДАН
АВСАН ХҮН БҮР**

9 БЭЛЭГТЭЙ

ЭСВЭЛ

БОНУС КАРТ 5%
урамшуулалтай



Зөвхөн "DELL Center"-т

Хаяг: Компьютер Ландын зүүн талд DELL Center

Холбогдох утас: 9906-9493, 9904-2031